



ИНД-149

Иргэний Нисэхийн Багц Дүрэм

Нисэх клуб – Гэрчилгээжүүлэлт

Иргэний нисэхийн ерөнхий газар

ДҮРМИЙН ТАЙЛБАР

ИНД-149 нь Нисэх клубын гэрчилгээжүүлэлтийн болон үйл ажиллагааны шаардлагыг тогтооно.

Энэ Дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ИНД-149-ийн цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-149, түүний нэмэлт, өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.

Мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 дугаар сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн энэхүү багц Дүрмийг боловсруулсан.

Өөрчлөлтийн түүх**Хүчин төгөлдөр огноо**

Анхны боловсруулалт

2002 оны 12 сарын 20

Нэмэлт, өөрчлөлт 1

2010 оны 05 сарын 11

Нэмэлт, өөрчлөлт 2 (Шинэчлэлт)

2018 оны ... сарын ...

Тэмдэглэл: ИНД-149-ийн шинэчлэлтийг англи болон монгол хэл дээр, NZ Part 149 А.2-т үндэслэн боловсруулсан болно.

Гарчиг

А Бүлэг – Ерөнхий зүйл	5
149.1. Хамрах хүрээ.....	5
149.3. Гэрчилгээжих шаардлага	5
149.5. Гэрчилгээ эзэмших хүсэлт.....	5
149.7. Гэрчилгээ олгох.....	5
149.9. Гэрчилгээ эзэмшигчийн эрх	5
149.11. Гэрчилгээний хугацаа	6
149.13. Гэрчилгээ сунгах	6
В Бүлэг – Гэрчилгээжүүлэлтийн шаардлага	6
149.51. Ажилтанд тавих шаардлага	6
149.53. Байгууламжийн шаардлага	7
149.55. Баримт бичиг	7
149.57. Бүртгэл	7
149.59. Хувь хүний гэрчилгээжүүлэлт	7
149.61. Нисэх спортын арга хэмжээ	8
149.62. Шилжилтийн зохицуулалт	8
149.63. Дотоод чанар баталгаажуулалт	8
149.65. Нисэх клубын Ерөнхий заавар.....	10
С Бүлэг – Үйл ажиллагааны шаардлага	11
149.101. Байнгын хэрэгжүүлэлт	11
149.103. Гэрчилгээ эзэмшигчийн байгууллагын өөрчлөлт.....	11

А Бүлэг – Ерөнхий зүйл

149.1. Хамрах хүрээ

Энэ Дүрэм нь нисэх клубын гэрчилгээжүүлэлт болон үйл ажиллагааны шаардлагыг тогтооно.

149.3. Гэрчилгээжих шаардлага

Нисэх клуб нь дараах гэрчилгээ эзэмшдэгээс бусад тохиолдолд, хувь хүний гэрчилгээжүүлэлт, эсхүл зэрэглэлийн хувьд, ИНД-ээр шаардсан нисэхийн баримт бичиг олгох ажиллагааг гүйцэтгэхгүй:

- (1) энэ Дүрмийн дагуу олгосон нисэх клубын; эсхүл
- (2) 2015 оны 04 сарын 01-нд хүчинтэй байсан, ИНД-103-ийн дагуу олгосон микролайтын байгууллагын.

149.5. Гэрчилгээ эзэмших хүсэлт

Нисэх клубын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь САА0149/01 маягыг бөглөж дараах баримт бичгийн хамт Даргад хүргүүлнэ:

- (1) 149.65-д шаардсан Ерөнхий заавар;
- (2) хуулийн дагуу дүрэмд заасан зохих төлбөрийн баримт.

149.7. Гэрчилгээ олгох

Хэрэв Дарга дараах шаардлагыг хангасан гэж үзвэл, хүсэлт гаргагч нь нисэх клубын гэрчилгээ авах эрхтэй:

- (1) 149.51(а)(1), (2), болон (3)-д шаардсан аливаа удирдах ажилтан, эсхүл ажилтнууд нь тохирох зөв хүн байх;
- (2) тухайн хүсэлт гаргагч нь В Бүлгийн шаардлагыг хангасан;
- (3) тухайн гэрчилгээг олгох нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй байх.

149.9. Гэрчилгээ эзэмшигчийн эрх

Нисэх клубын гэрчилгээ эзэмшигч нь:

- (1) удирдах ажилтан, эсхүл ажилтнуудын эзэмшиж буй шилжсэн эрхийн хүрээнд тухайн гэрчилгээнд заасан зэрэглэл болон гэрчилгээг хувь хүнд олгох ажлыг зохион байгуулах;
- (2) тухайн эрхийг гэрчилгээнд заасан бол, ИНД-91-ийн дагуу нисэх спортын арга хэмжээг зохион байгуулах;
- (3) тухайн эрхийг гэрчилгээнд заасан бол, ИНД-ээр ИНД-149-ийн байгууллагаар хэрэгжүүлэхийг шаардсан аливаа бусад эрхийг хэрэгжүүлж болно.

149.11. Гэрчилгээний хугацаа

- (a) Нисэх клубын гэрчилгээг 5 жил хүртэл хугацаагаар олгож, эсхүл сунгаж болно.
- (b) Нисэх клубын гэрчилгээ нь түүний хугацаа дууссан, эсхүл түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосноос бусад тохиолдолд хүчинтэй хэвээр байна.
- (c) Нисэх клубын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээний хугацаа дууссан, эсхүл хүчингүй болсон бол тухайн гэрчилгээг Даргад шууд хураалгана.
- (d) Нисэх клубын гэрчилгээг түдгэлзүүлсэн бол эзэмшигч нь зохих тэмдэглэл хийлгэхээр гэрчилгээг Даргад шууд хүргүүлнэ.

149.13. Гэрчилгээ сунгах

- (a) Нисэх клубын гэрчилгээ сунгуулах хүсэлтийг Нисэх клубын гэрчилгээ эзэмшигч САА 24149/01 маягтаар гаргана.
- (b) Тухайн хүсэлтийг, гэрчилгээнд заасан сунгах хугацаанд, хэрэв гэрчилгээнд сунгах хугацаа заагаагүй бол, гэрчилгээний хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө Даргад хүргүүлнэ.

В Бүлэг – Гэрчилгээжүүлэлтийн шаардлага**149.51. Ажилтанд тавих шаардлага**

- (a) Нисэх клубын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах ажилтныг гэрээгээр, үндсэн ажилтнаар, эсхүл оролцуулах хэлбэрээр авч ажиллуулна:
 - (1) тухайн байгууллагын гүйцэтгэж буй бүх ажиллагааг энэ Дүрэмд заасан шаардлагын дагуу гүйцэтгэж байгааг бататгах тухайн байгууллагын эрх бүхий, гүйцэтгэх захирлаар тодорхойлогдсон удирдах ажилтан;
 - (2) тухайн гэрчилгээ, зэрэглэл олгох зорилгоор, Даргаас шилжүүлсэн эрх эзэмших удирдах ажилтан, эсхүл ажилтнууд;
 - (3) тухайн хүсэлт гаргагчийн байгууллага нь энэ Дүрмийн шаардлага хангаж байгааг бататгахыг хариуцах удирдах ажилтан, эсхүл ажилтнууд. Эдгээр удирдах ажилтан, эсхүл ажилтнууд нь гүйцэтгэх захиралд шууд захирагдана;
 - (4) тухайн хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан ажиллагааг гүйцэтгэх хангалттай тооны ажилтан.
- (b) Тухайн хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:
 - (1) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх хариуцлага хүлээсэн ажилтны ур чадварыг үнэлэх, хадгалах журмыг тогтоох;

- (2) удирдах ажилтан, эсхүл ажилтнуудын эзэмшиж буй аливаа шилжүүлсэн эрхийг хэрэгжүүлэх журмыг тогтоох;
- (3) энэ Дүрмийн дагуу хариуцлага хүлээж буй ажилтнуудад тухайн үүрэг хариуцлагаа бүрэн хэрэгжүүлэх эрхийг бичгээр олгох.

149.53. Байгууламжийн шаардлага

Нисэх клубын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, байгууламжийн боломж болон нөөц байгууллагын Ерөнхий зааварт заасан тухайн ажиллагаанд нийцэж байгааг бататгана.

149.55. Баримт бичиг

(a) Нисэх клубын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч бүр, тухайн хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан ажиллагааны журмыг тогтооход шаардлагатай бүх холбогдох тоног төхөөрөмжийн заавар, техникийн стандарт болон практик аргачлал, техникийн бюллетень, зааварчилгаа, хууль тогтоомж болон бусад баримт бичгийн хувийг ашиглахад бэлэн байлгана. Энэ баримт бичигт менежмент болон байгууллагатай холбоотой хүний хүчин зүйлийн материал багтсан байна.

(b) Хүсэлт гаргагч нь энэ зүйлийн (a)-д шаардсан бүх холбогдох баримт бичгийг хянах, нэмэлт өөрчлөлт оруулах журмыг тогтооно.

149.57. Бүртгэл

(a) Нисэх клубын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь тухайн хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан үйл ажиллагаанд шаардлагатай бүртгэлийг таньж тогтоох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, хөтлөх болон устгах журмыг тогтооно.

(b) Тухайн журам нь дараах шаардлагыг бататгана:

- (1) 149.63-д заасан журмын дагуу, тухайн хүсэлт гаргагчийн байгууллагын дотоод чанар баталгаажуулалтын гүйцэтгэсэн ажиллагаа бүр бүртгэлтэй болохыг;
- (2) тухайн хүсэлт гаргагчийн байгууллагын нэрийн өмнөөс үйл ажиллагаанд оролцдог хүн бүр бүртгэлтэй байхыг. Тухайн бүртгэлд тэдгээрийн туршлага, мэргэшил, сургалт, ур чадварын үнэлгээний дэлгэрэнгүйг багтаана;
- (3) тухайн байгууллагаас олгосон хувь хүний гэрчилгээ болон зэрэглэл бүртгэлтэй болохыг;
- (4) бүх бүртгэл нь гаргацтай бөгөөд засварлах боломжгүй болохыг;
- (5) бүх бүртгэлийг, тухайн бүртгэлд сүүлчийн бичилт хийснээс хойш 3-аас доошгүй жил хадгалдаг болохыг.

149.59. Хувь хүний гэрчилгээжүүлэлт

(a) Нисэх клубын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч бүр, хувь хүний гэрчилгээ, эсхүл зэрэглэл олгох зорилгоор дараах журмыг тогтооно:

- (1) дүйцэх мэргэшил эзэмшигчийг багтаасан, хувь хүний ур чадварын үнэлгээ хийх;
- (2) тухайн хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заагдсан гэрчилгээ болон зэрэглэл олгох;
- (3) Даргаас шилжүүлсэн эрхийн хүрээнд олгосон гэрчилгээ, эсхүл зэрэглэл эзэмшиж буй этгээдийн ур чадварыг үнэлэх болон хадгалах.

(b) Энэ зүйлийн (a)-д шаардсан журам нь ИНД болон Монгол Улсын хуулийн шаардлагыг хангах журмыг багтаасан байна.

149.61. Нисэх спортын арга хэмжээ

Нисэх спортын арга хэмжээ зохион байгуулах эрхтэй нисэх клубын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журмыг тогтоох үүрэгтэй:

- (1) ИНД-91-д нийцэж байгааг бататгах;
- (2) нисэхийн аюулгүй байдалд учирч болзошгүй аюулыг тодорхойлох болон тухайн эрсдэл нь үнэлэгдсэн бөгөөд зохицуулагдсаныг бататгах.

149.62. Шилжилтийн зохицуулалт

(a) Нисэх спортын арга хэмжээ зохион байгуулах эрхтэй нисэх клубын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь 2018 оны 02 сарын 01 хүртэл 149.61(2)-ыг мөрдөх шаардлагагүй.

(b) Энэ зүйл нь 2018 оны 02 сарын 01ний өдрийг хүртэл хүчинтэй байна.

149.63. Дотоод чанар баталгаажуулалт

(a) Нисэх клубын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч бүр, энэ Дүрмээр шаардсан журмын хэрэгжилт болон тохирлыг бататгах зорилгоор дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлсэн байна.

(b) Дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоо нь дараах журмыг багтаасан байна:

- (1) тухайн хүсэлт гаргагчийн байгууллагын зорилго болон түүний гишүүдийн хүсэл эрмэлзэл, хэрэгцээнд тохирсон аюулгүй байдлын бодлого болон **аюулгүй байдлын бодлогын** журам;
- (2) тухайн тогтолцоонд оршин байгаа хүндрэлтэй асуудал, эсхүл хүндрэлтэй асуудлын бодит шалтгааныг тогтоох зорилгоор ажилтнууд болон гишүүдийн санал хүсэлтийг багтаасан **чанарын үзүүлэлтэд** мониторинг хийдгийг бататгах журам;
- (3) тухайн тогтолцоонд тогтоогдсон хүндрэлтэй асуудлыг засаж залруулсныг бататгах **залруулах арга хэмжээний** журам;
- (4) тухайн тогтолцоонд тогтоогдсон хүндрэлтэй асуудлын бодит шалтгааныг арилгасныг бататгах **урьдчилан сэргийлэх арга хэмжээний** журам;

- (5) тухайн хүсэлт гаргагчийн байгууллага нь аюулгүй байдлын бодлогодоо нийцэж байгаад аудит хийх **дотоод аудитын** хөтөлбөр;
- (6) дотоод чанар баталгаажуулалтын тогтолцооны байнгын тохирол болон үр дүн нь энэ Дүрмийн тухайн шаардлагыг хангаж байгааг бататгах **удирдлагын үнэлгээний** журам.
- (с) Аюулгүй байдлын бодлогын журам нь тухайн аюулгүй байдлын бодлогыг байгууллагын бүх түвшинд ойлгодог, хэрэгжүүлдэг болон мөрддөг болохыг бататгана.
- (d) Залруулах арга хэмжээний журамд дараах үйл ажиллагааг хэрхэн гүйцэтгэхийг тодорхойлсон байна:
- (1) оршиж буй хүндрэлтэй асуудлыг залруулах;
 - (2) тухайн арга хэмжээний үр дүнг бататгах зорилгоор залруулах арга хэмжээг эргэн шалгах;
 - (3) залруулах арга хэмжээний үр дүнд, журамд өөрчлөлт оруулах;
 - (4) удирдлага, аливаа залруулах арга хэмжээний үр дүнг үнэлэх.
- (е) Урьдчилан сэргийлэх арга хэмжээний журам нь дараах үйл ажиллагааг хэрхэн гүйцэтгэхийг тодорхойлсон байна:
- (1) болзошгүй хүндрэлтэй асуудлыг залруулах;
 - (2) тухайн арга хэмжээний үр дүнг бататгах зорилгоор, урьдчилан сэргийлэх арга хэмжээг эргэн шалгах;
 - (3) урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнд, журамд өөрчлөлт оруулах;
 - (4) удирдлага, аливаа урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнг үнэлэх.
- (f) Дотоод аудитын хөтөлбөр нь:
- (1) аудит хийгдэх ажиллагааны шинж чанартай уялдуулан аудитын давтамж болон байрлалыг заана;
 - (2) аудитыг сургалтад хамрагдсан, тухайн аудит хийгдэж буй ажиллагаанд шууд хариуцлага хүлээдэг этгээдээс хамааралгүй, аудитын ажилтан хийдгийг бататгана;
 - (3) аудитын үр дүнг, аудит хийгдсэн ажиллагааг хариуцсан ажилтанд болон дотоод аудит хариуцсан менежерт мэдээлдэг болохыг бататгана;
 - (4) хэрэв аудитаар хүндрэлтэй асуудал илэрсэн бол, аудит хийгдсэн ажиллагааг хариуцсан ажилтнаас залруулах, эсхүл урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахыг шаардана;
 - (5) авч хэрэгжүүлсэн аливаа залруулах, эсхүл урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнд үнэлгээ хийх зорилгоор эргэн шалгах аудит хийдгийг бататгана.
- (g) Удирдлагын үнэлгээ хийх журам нь:

- (1) тухайн тогтолцооны байнгын үр дүнтэй байх хэрэгцээ шаардлагыг авч үзсэний үндсэн дээр, чанар баталгаажуулалтын тогтолцооны удирдлагын үнэлгээ хийх давтамжийг тодорхойлно;
- (2) тухайн чанар баталгаажуулалтын тогтолцоонд үнэлгээ хийх менежерийг тогтооно;
- (3) тухайн үнэлгээний үр дүнг тооцон дүгнэж, бүртгэдэг болохыг бататгана.

(h) Дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтан нь аюулгүй байдалд нөлөөлөх асуудлаар гүйцэтгэх захиралд шууд хандана.

149.65. Нисэх клубын Ерөнхий заавар

(a) Нисэх клубын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах холбогдох журмыг багтаасан Ерөнхий зааврыг Даргад ирүүлэх үүрэгтэй:

- (1) Ерөнхий заавар болон түүнд багтсан бусад журам дараах шаардлагыг багтаасныг бататган, хүсэлт гаргагчийн байгууллагын нэрийн өмнөөс гүйцэтгэх захирал гарын үсэг зурсан мэдэгдэл:
 - (i) тухайн байгууллагыг тодорхойлох ба энэ Дүрмийн байнгын хэрэгжүүлэлтийг бататгах арга, аргачлалыг харуулах;
 - (ii) түүнийг байнга дагаж мөрдөхийг шаарддаг болохыг;
- (2) 149.51(a)(1), (2) болон (3)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнуудын албан тушаал болон нэр;
- (3) 149.51(a)(1), (2) болон (3)-т шаардсан, тухайн байгууллагын нэрийн өмнөөс Дарга, эсхүл Эрх бүхий байгууллагатай шууд харьцах, тэдний хариуцсан асуудлыг багтаасан удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнуудын үүрэг болон хариуцлага;
- (4) 149.51(a)(3)-д заасан удирдах ажилтан, эсхүл ажилтнуудын хариуцлагын шугаман хамаарлыг харуулсан, энэ зүйлийн (a)(6)-гийн дагуу заасан байрлал бүрийг хамарсан байгууллагын бүтцийн зураг;
- (5) тухайн гэрчилгээний хүрээнд явуулах ажиллагаа бүрийн тодорхойлолт;
- (6) ажиллагаа бүрийг явуулах үндсэн байрлал;
- (7) 149.53-т шаардсан байгууламжийн тодорхойлолт;
- (8) дараах зүйлээр шаардсан журмын дэлгэрэнгүй:
 - (i) 149.51(b) (1) - ажилтны ур чадварын талаар;
 - (ii) 149.51(b) (2) - удирдах ажилтан, эсхүл ажилтнуудын эзэмшиж буй аливаа шилжүүлсэн эрхийг хэрэгжүүлэх талаар;
 - (iii) 149.55(b) - баримт бичгийн хяналт, нэмэлт өөрчлөлтийн талаар;
 - (iv) 149.57(a) - бүртгэлийг таньж тогтоох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, хөтлөх болон устгах талаар;

- (v) 149.59(a) - ажилтныг үнэлэх, гэрчилгээ болон зэрэглэл олгох, гэрчилгээ, зэрэглэл эзэмшигчийн ур чадварын үнэлгээ хийх болон хадгалах талаар;
 - (vi) 149.61 - аюулыг таньж тогтоох болон эрсдэлийн удирдлагыг багтаасан нисэх спортын арга хэмжээ зохион байгуулах талаар;
 - (vii) 149.63 - тухайн байгууллагын дотоод чанар баталгаажуулалтын талаар;
- (9) Ерөнхий зааврыг хянах, нэмэлт өөрчлөлт хийх болон түгээх журам.
- (b) Тухайн хүсэлт гаргагчийн Ерөнхий заавар нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц байх ёстой.

С Бүлэг – Үйл ажиллагааны шаардлага

149.101. Байнгын хэрэгжүүлэлт

Нисэх клубын гэрчилгээ эзэмшигч бүр нь:

- (1) байгууллагын Ерөнхий зааврын хүчинтэй нэгээс доошгүй хувийг Ерөнхий зааварт заасан үндсэн байрлал бүрт хадгална;
- (2) Ерөнхий зааварт заасан бүх журмыг дагаж мөрдөнө;
- (3) Ерөнхий зааврын холбогдох бүлэг бүрийг, өөрийн үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ажилтанд хэрэглэх боломжтой байлгана;
- (4) В Бүлгийн шаардлага болон стандартыг байнга хангана;
- (5) САА24149/01 маягтаар шаардсан үйлчилгээний хаяг, утасны дугаар, факсын дугаарын аливаа өөрчлөлтийг Даргад шууд мэдэгдэнэ.

149.103. Гэрчилгээ эзэмшигчийн байгууллагын өөрчлөлт

- (a) Нисэх клубын гэрчилгээ эзэмшигч, Ерөнхий зааврын нэмэлт өөрчлөлт нь тухайн эзэмшигчийн байгууллагын хүчинтэй тодорхойлолт хэвээр хадгалагдаж байхаар хийгдсэнийг бататгах үүрэгтэй.
- (b) Гэрчилгээ эзэмшигч нь тухайн эзэмшигчийн Ерөнхий зааварт хийсэн аливаа нэмэлт өөрчлөлт нь энэ Дүрмийн холбогдох шаардлагыг хангаж байгаа ба Ерөнхий зааварт заасан нэмэлт өөрчлөлт оруулах журмыг дагаж мөрдсөнийг бататгана.
- (c) Гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий зааварт нэмэлт өөрчлөлт оруулсны дараа, Даргын хэрэгцээнд зориулж, нэмэлт өөрчлөлт бүрийн хувийг Даргад цаг алдалгүй хүргүүлэх үүрэгтэй.
- (d) Гэрчилгээ эзэмшигч нь дараах аливаа өөрчлөлтийг хийхээс өмнө Даргаас урьдчилан зөвшөөрөл авсан байх шаардлагатай:
- (1) тухайн гүйцэтгэх захирлыг;
 - (2) нэр заагдсан удирдах ажилтныг;

- (3) Даргаас шилжүүлсэн эрх эзэмшигч, эсхүл эзэмшигчдийг;
- (4) тухайн гэрчилгээгээр зөвшөөрсөн ажиллагааг;
- (5) тухайн үйл ажиллагаа явагдах үндсэн байрлалыг;
- (6) хувь хүнд үнэлгээ хийх болон гэрчилгээжүүлэх журмыг;
- (7) нисэх спортын арга хэмжээ зохион байгуулах журмыг.

(e) Хамааралгүй

(f) Дарга энэ зүйлийн (d)-д заасан аливаа өөрчлөлтийг хийж байх үед, эсхүл хийсний дараа гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаандаа мөрдөх нөхцөлийг тогтоож болно.

(g) Гэрчилгээ эзэмшигч, энэ зүйлийн (f)-ийн дагуу Даргын тогтоосон аливаа нөхцөлийг дагаж мөрдөнө.

(h) Хэрэв энэ зүйлд заасан аливаа өөрчлөлт нь тухайн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулахыг шаардсан бол, тухайн гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээг Даргад зохих бичилт хийлгэхээр нэн даруй хүргүүлнэ.

(i) Дарга тухайн нэмэлт өөрчлөлтийг хийх нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд шаардлагатай гэж үзвэл, Гэрчилгээ эзэмшигч Ерөнхий заавартаа тухайн нэмэлт өөрчлөлтийг оруулна.

--oOo--